

Нэгдүгээр амаржих газар

Тус амаржих газар нь анх 1928 оны 4 дүгээр сарын 3-ний өдрийн Засгийн газрын эрхлэх товчооны гишүүдийн 59 дүгээр хурлын тогтоолоор тэр үеийн төв больниц, клиник эмнэлгийн дэргэд 3 сувилагчийн орон тоотой 6 ортой 900 төгрөг ний төсөвтэй төрөх тасаг байгуулсан нь Клиникийн I амаржих газрын үндсэн суурь нь болжээ. Тус амаржих газраас 1960 онд Нийслэлийн 2 дугаар амаржих газар, 1962 онд Цацраг эмнэлэг, 1966 онд Здугаар амаржих газар, 1987 онд Эх нялхсын эрдэм шинжилгээний хүрээлэн ЭНЭШХ, салбарлан байгуулагдсан.

1933 онд Төв больницын мэс заслын тасгийг түшиглүүлэн 10 ортой эмэгтэйчүүдийн тасгийг байгуулснаар эмэгтэйчүүдийн өвчний тусламжийг үзүүлэх болсон. Төрөх тасгийн анхны их эмчээр Зөвлөлтийн эмч Над-от ажиллаж байсан. 1935 онд эх барихын 30 ор, 1940 онд 40 ор, эмэгтэйчүүдийн 20 ор бүгд 90 ортой болж өргөжжээ.

1947 оны 3 сараас МУИС-ын Анагаах ухааны факультет ийн эх барихын тэнхим байгуулагдсанаар эмч оюутны сургалтын бааз болж эхэлсэн бөгөөд ЗХУ-С уригдаж ирсэн В.А.Анисимов анхны танхимын эрхлэгчээр ажиллах болсон.

1986 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор эх барих эмэгтэйчүүдийн өвчнийг эмчлэх тасгийн бие даасан больниц болгох шийдвэр гарч анхны төрөх газарт зориулагдсан барилга барьж 1951 онд ашиглалтад оруулж "Төв төрөх нэртэйгээр нээгджээ.

1957 оноос тус төрөх газрын дэргэд эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх тасагтай болж өргөжсөн. Төрөх газрын дэргэд 1955 онд 100 ортой эмэгтэйчүүдийн тасгийг бие даасан больницын хэмжээнд байгуулан ажиллажээ.

Тус амаржих газрыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1967 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн №396 дугаар тогтоолын дагуу 1968 онд Клиникийн амаржих газар болгон өргөтгөсөн байна.

1978 онд 50 жилийн ойгоор төрийн хүндэт одон "Алтан гадас аар шагнуулсан:

1981 онд материаллаг бааз жилээс жилд өргөжиж улс хотын хэмжээнд эх барих эмэгтэйчүүдийн тусламжийг үзүүлдэг 405 ортой нарийн мэргэжлийн төв болсон.

1995 онд хүүхэд-эд ээлтэй болзлыг хангаж, гэрчилгээ авч сүүлийн үед био монитор, сальпингография зэрэг оношлог оо шинжилгээний аргыг нэвтрүүлсэн.

2000 онд Эх барих эмэгтэйчүүдийн эмчийн резидентийн сургалт эрхэлсэн Төгсөлтийнх дараах сургалтын алба үүсгэн байгуулагдсан.

2002 онд КНАГ нь магадлан итгэмжлэлийн шалгалтаар амжилттай дүн үзүүлж Эрүүл мэндийн тусламж үзүүлэх, үйл ажиллагааны шаардлагыг хангасны учир магадлан итгэмжлэгдэж улмаар 2005 онд дахин 4 жилээр сунгагдсан

Тус амаржих газраас Д.Тамжав, Г.Дуламжав, Ц.Дэмид, Д.Цэвэлмаа, Б.Бадам,Б.Жав, Б.Үйлст, Б.Бүлтэн, нар гавьяат эмч М.Дамбадорж гавьяат багш цолоор, Б.Жав,Б.Лувсан-Ёндон, С.Дорж, Д.Ичинхорлоо, Д.Цэндсүрэн, Д.Дариймаа, Д.Баттогтох, Ш.Цэрэнсамбуу нар Анагаах ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.